

2026 оны 05 сарын 15 өдөр

№ 07

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэх заалт мөн хуулийн 62.1.9, 62.1.13 дахь заалт болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018.12.14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын зар мэдээг хүргэх” журмын 2 болон 3 дугаар зүйлийн заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Махимпэкс” ХК ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 14:00 цагт компанийн пэйж хуудсаар шууд дамжуулан цахимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай. Үүнд:
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах
 4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 03 ний өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг “Санхүүгийн Зохицуулах Хороо”, “Хөрөнгийн Бирж”-д мэдэгдэх өдрийг 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр болон 4 дүгээр сарын 2-ны өдрүүдэд байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай зарыг 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулах, 3 дугаар сарын 18-ны өдөр болон 4 дүгээр сарын 2-ны өдрүүдэд өдөр дутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компани дээр 2026 оны 03-р сарын 23-ны өдрийн дотор бэлэн болгож, Хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

Үүнд:

6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай болон Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар

6.2 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2026 оны бизнес төлөвлөгөө

6.3 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга

6.4 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсөв

6.5 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас гарах шийдвэрийн төсөл

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү шийдвэрийн Хавсралт №02-оор баталсугай.

9. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №03-аар баталсугай.

10. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2026.04.24-ний өдрийн 14:00 цагаар тогтоосугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Борлуулалтын албаны дарга Н.Алтан-Эрдэнэ, Нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр, Тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Д.Самдан, Ж.Сүхболд нарыг сонгосугай.

12. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай.

Комиссын дарга: Б.Хонгорзул /Нягтлан бодогч/

Гишүүд: Ч.Мөнх-Очир /Нягтлан бодогч/

Г.Солонго /Нягтлан бодогч/

Д.Лхагвасүрэн /Нягтлан бодогч/

13. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Комиссын дарга: Н.Одгэрэл /Үйлдвэрийн дарга/

Нарийн бичгийн дарга: И.Өлзийбаяр /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Гишүүд Б.Баянмөнх /ЗХНА-ы дарга/

Н.Маралсүрэн /Ерөнхий инженер/

П.Амартайван /Ерөнхий менежер/

Б.Халиун /Хүний нөөцийн менежер

14. Компанийн Хувьцаа Эзэмшигчдэд танилцуулах хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга /Н.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.ЦЭНГҮҮН

